



МУИС-ийн ОЮУТАН МОНГОЛЫН ИРЭЭДҮЙ

Мэдээ-1

2014 он

ОЮУТАН ТАНЫ СУРГАЛТЫН ТӨЛБӨР ЮУНД ЗАРЦУУЛАГДДАГ ВЭ?

МУИС-ийн оюутны төлбөр: бүтэц, хэмжээ

2014-2015 оны хичээлийн жилд МУИС-ийн бакалавр, магистр, докторын хөтөлбөрт суралцаж буй оюутан суралцагсдын төлбөр нь дараах байдалтай байна.

Бакалаврын хөтөлбөрийн оюутнууд:

1. Сургалтын суурь төлбөр буюу нэг хичээлийн жилд 200.0 мянган төгрөг,
2. Багц цагийн төлбөр (дунджаар нэг багц цаг 53.1 мян.төгрөг.)

МУИС-ийн ахисан түвшний хөтөлбөрийн оюутан суралцагсад:

1. Сургалтын суурь төлбөр нэг хичээлийн жилд 300.0 мянган төгрөг,
2. Багц цагийн цагийн төлбөр: дунджаар нэг багц цаг
-Докторант 112,0 мян.төгрөг
-Магистрант 89,6 мян.төгрөг байна.

МУИС-ийн төсвийн хэдэн хувийг оюутны төлбөр эзэлдэг вэ?

2014 оны байдлаар нийт төсвийн **61.4** хувийг эзэлж байна. Өнгөрсөн 2013 оны төсөвтэй харьцуулахад энэ тоо **16.1** хувиар буурсан бөгөөд МУИС-ийн шинэчлэлийн бодлого болон төсвийн хөрөнгө оруулалт **7.5** хувь нэмэгдсэнээр оюутны төлбөрт ирдэг төсвийн дарамт буурч сургалтын суурь хураамжийг энэ онд нэмэхгүй өмнөх жилийн хэмжээнд барих боломж бүрдлээ.

Таны төлсөн сургалтын төлбөр юунд зарцуулагддаг вэ?

Сургалтын суурь төлбөр нь оюутны сурах үйл ажиллагааг дэмждэг үйлчилгээний дараах зардлыг САНХҮҮЖҮҮЛДЭГ. Үүнд:

МУИС-ийн эрдмийн хамт олон багш профессор, бакалавр, магистр, докторын хөтөлбөрийн оюутнуудад үзүүлдэг төвлөрсөн үйлчилгээ-Номын сан: ном бүрдүүлэлт, олон улсын сэтгүүлийн онлайн эрх, номын сан болон оюутны бие даах төвийн ажилтаны цалин хөлс, мэдээлэл, программ хангамж, сургалтын үйл ажиллагаатай холбогдсон нэгдсэн үйлчилгээ, сургалтын нэгдсэн алба болон захиргаа, удирдлагын зардлын тодорхой хувь хэмжээ, оюутны байгууллага, клубын зардал

Сургалтын орчинг сайжруулах -Хангамж үйлчилгээний алба, үйлчилгээний ажилчдын цалин хөлс, үйл ажиллагааны зардал, МУИС-ийн хөрөнгөөр хийж буй барилга байгууламж, оюутны болоод хичээлийн анги танхмийн их ба урсгал засвар, сурах орчны тохижилт, сургалт, судалгаа болоод бусад тоног төхөөрөмж ТЭХ-ын элэгдэл.

Оюутны мэдээллийн үйлчилгээ: Оюутны гарын авлага, холбогдох мэдээлэл, Мэдээлэл технологийн албаны ажилтнуудын цалин хөлс, үйл ажиллагааны төсөв, сургалтын Си Си системийн үйл ажиллагаа, програм хөгжүүлэлт, техник тоног төхөөрөмжийн шинэчлэл,

Багц цагийн төлбөрөөс МУИС дараах зардлыг САНХҮҮЖҮҮДЭГ. Үүнд:

Оюутны сурах үйл ажиллагаанд шууд холбоотой сургалтын үйлчилгээ: багш профессорууд, салбар сургалтын албадын мэргэжилтэн, зааварлагчдын цалин хөлс, үйл ажиллагааны зардал, хээрийн болон үйлдвэрлэлийн дадлага, сургалтын үйлчилгээний ажилчдын цалин хөлс, хичээл практик, эрдэм шинжилгээний хурал семинарын зардал, оюутны академик үйлчилгээ, оюутны тэтгэлэг, олимпиад, оюутны дунд зохиогддог бүх төрлийн уралдаан тэмцээний зардал, гадаад багш болон багшийн үйл ажиллагаа, хөгжлийг дэмжих зардал, интернэт, сургалтын тоног төхөөрөмж, эд хогшлын зардал.

Сургалтын төлбөрийг хэн баталдаг вэ?

Монголын улсын боловсролын холбогдох хууль тогтоомжид заасны дагуу МУИС-ийн Удирдах зөвлөл нь сургалтын болоод оюутны дотуур байрны төлбөрийн хэмжээг шийдвэрлэн тогтоодог.

Сургалтын албаны үйл ажиллагааг сайжруулах, үйлчилгээний соёлыг дээшлүүлэх талаар ямар ажил хийж байгаа вэ?


МУИС-ийн оюутан судлахаар сонгосон хичээлийн багц цаг болон суурь төлбөр төлдөг бөгөөд ХААН болон ГОЛОМТ банкаар дамжуулан картаар онлайнаар хийдэг тул хэн нэгийг эрж хайж явах шаардлагагүй байдаг. Түүнчлэн элсэлтийн хугацаанд МУИС-ийн хичээлийн 1.2. 3. 4. 5 дугаар байрны нэгдүгээр давхарт "Мэдээ, Лавлагааны цэг" ажиллаж бүх талын мэдээлэл өгч байгаагийн зэрэгцээ харилцагч банкны ажилтнууд ажиллаж гарсан аливаа асуудлыг газар дээр нь шийдвэрлэж байна. МУИС-д элсч байгаа бүх оюутанд зориулж "Оюутны гарын авлага" боловсруулж оюутнуудад тараасан бөгөөд МУИС-ийн цахим хуудсанд байршуулсан байгаа. Энэхүү гарын авлагад оюутанд шаардлагатай бүх мэдээлэл, зааварчилгааг оруулсан болно.

Өнөөдрийн оргил үед Сургалтын албад нэг дор 4000 орчим шинээр элсэж байгаа оюутнууд, тэдний эцэг эх, бусад иргэд, одоо сурч байгаа 18000 орчим оюутанд зэрэг үйлчилж байгаа тул ачаалал ихтэй гэдгийг ойлгож, соёлтой үйлчлүүлэхийг бид оюутнуудаасаа хүсч байна. МУИС-ийн оюутнууд гарын авлагаа <http://news.num.edu.mn/?p=19278> линкээс татан авч үзэж болно. МУИС-ийн бусад бүх дүрэм, журам заавруудыг www.num.edu.mn цахим хуудаснаас уншиж болно.

МУИС нь оюутанд үйлчлэх үйлчилгээг чанартай соёлтой болгоход онцгой анхаарч ажиллаж байна. Энэ хичээлийн жилээс нийт ажилтан албан хаагчдын үйлчилгээний соёлыг дээшлүүлэх сургалт явуулах, үзүүлж буй үйлчилгээ, харилцааны чанар, соёлын талаар оюутны санал бодлыг судалж, гомдлын мөрөөр арга хэмжээ авах, нийт ажилтанаа энгэрийн тэмдэгтэй болгож, нэг цэгийн үйлчилгээг нэвтрүүлж, аливаа лавлагаа, тодорхойлолтыг оюутан өөрөө ТҮЦ машинаас авдаг болохоор бэлтгэл ажлыг хангаж байна. Энэ бүхэн үр дүнгээ өгнө гэдэгт эргэлзэхгүй байна.

МУИС-ийн захиргаа, Сургалтын нэгдсэн алба

Хичээлийн байр, оюутны байрны байршил



МУИС-ИЙН СУРГАЛТЫН НЭГДСЭН АЛБА

МУИС-ийн хичээлийн I байр,
 Их Сургуулийн гудамж - 1, Бага тойруу,
 Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар

<http://num.edu.mn>

our@num.edu.mn,